

**МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛЫН ХӨГЖЛИЙН
ОНОЛ, ТҮҮХИЙН ЗАРИМ АСУУДАЛ**

Д.Галбаатар*

Аливаа урлаг реалист бус мөн чанартай. Монгол уран зохиолын туурвил зүй, зүй тогтол ч адил юм. Доктор Ч.Билигсайхан *“Монголын утга зохиол дахь сэргэн мандалтын үеийг тодруулах асуудалд”* өгүүлэлдээ: *“Дэлхийн уран зохиолд YIII зуунд Хятад, X зуунд Перс /С.Дулам/”,* улмаар XIY зуунаас европ дахинд сэргэн мандалтын томоохон үеүд тохиолдсон хийгээд бусад улс үндэстнүүдийн уран зохиолд харилцан адилгүй цаг үед тохиолдсон тухай өгүүлээд *“... монголчуудын хувьд XVII-XVIII зууны үед монголын урлаг, уран зохиолд сэргэн мандалтын үе болж өнгөрчээ” /1.№4/* гэсэн дүгнэлт анхаарал татдаг. Сэргэн мандлын ерөнхий зүй тогтол нь европ дахины хувьд феодализм хөгжлийнхөө дээд шатанд хүрч, бүс нутгийн хөгжингүй орнуудад капитализмын шинэ харилцаанд шилжих үеийн шинж тэмдгүүд үзэгдэн, шинэ нийгмийн оюун санаа бүрэлдэж эхэлсэн түүхэн үетэй уялдан үүсч, шашны хязгааргүй эрх дарх бүхий ёс дэглэмийг эсэргүүцсэн, хүнлэг энэрэнгүй үзэл, соёлжингүй нийгэм, ялангуяа суурин соёл иргэншил, хотжилтой уялдан гарч иржээ.

Монголчуудын хувьд сэргэн мандлын үзэл санааны дэлгэрэл нэлээд онцлогтойг тэмдэглэх хэрэгтэй. XVII зуун гэхэд монголын соёл, утга зохиол, шинжлэх ухааны хөгжилд шарын шашны нөлөө, оролцоо их, ноёрхох байр суурьтай байсан ч түүний хүрээнд анагаах ухаан, гүн ухаан, хэл шинжлэл, уран баримал, уран барилга, түүх, урлахуй ухаан, орчуулга, уран зохиол эрчимтэй хөгжиж, түүн лүгээ олон салбарт зэрэг ажилладаг томоохон сэтгэгч, эрдэмтэд, уран бүтээлчид төрж гарчээ. Ф.Энгельс сэргэн мандалтын үеийг *“... аварга хүмүүс хэрэгтэй байсан бөгөөд оюун санаа, хүнлэг сэтгэл, олон талын авъяас, эрдэм мэдлэгтэй их хүмүүсийг төрүүлэн” /2.3/* гаргасан гэх онол ёсоор XYI-XYIII зууны үед ч монголын соёл, шашин, шинжлэх ухаан, урлагийн салбарт тийм их хүмүүс төрж гарчээ. Тоймловол: Эх оронч, шүлэгч, халхын Цогт хун тайж /1581-1637/. Ойрдын Зая Бандида Намхайжамц /1899-1662/, Жанжа хутагт Ролбидорж /1717-1786/, түүхч, зохиолч Саган цэцэн /1604-?/, их түүхч Лувсанданзан, Рашпунцаг, /тодорхойгүй/ Зая бандид Лувсанпэрэнлэй /1642-1715/, сүмбэ хамба Ишбалжир /1704-1788/, цахар гэвш Лувсанчүлтэм /1740-1810/, Алшаагийн Дандар лхарамба /1759-1842/, өндөр гэгээн Занабазар /1635-1723/, их хүрээний Агваантүвдэн /XVIII-XIX зууны эх/, ханбо Агваанхайдав /1779-1838/, яруу найрагч, ноён хутагт Д.Данзанравжаа /1803-1856/ зэрэг олон талын мэдлэг боловсролтой мэргэд төрсөн нь монголын соёлын сэргэн мандлын үеийг төлөөлөх төдийгүй улс үндэстнээ соён гэгээрүүлэл рүү чиглүүлжээ. Ийн Монголын нийгмийн өвөрмөц онцлогтой уялдан, нэг

* МУИС-ийн МХСС-ийн багш, доктор, профессор

талаас өрнө дахинд хүчтэй гарч чиглэл болж асан классицизмын үеийг ч монголын сэргэн мандлын үеийг хамтад нь эдгээр хүмүүс төлөөлөн өнгөрсөн байх магадлал өндөр юм. Нөгөө талдаа монголчууд Манж Чин улс давхар дарлал /колони/-д орсноор үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын үзэл санаа хүчтэй дэлгэрч нийгмийн нийт анги давхаргыг хамран өргөжсөнөөр шашны зан үйл, сургаал номлолд бурхан бодьсадын явдлаас илүү хүний мөн чанарт анхаарах хандлага гүнзгийрч, мөнхүү шашны лам хуврагууд ёс дэг, сахил санваараа зөрчих нь ерийн үзэгдэл болж хувирсан нь сэргэн мандлын шав суурийг тавих нөгөө нэг чухал хүчин зүйл нь байсан бололтой. Дарлал мөлжлөгийн зовлон зүдгүүр гэгээлэг сэхээтнүүдийн хүнлэг энэрэнгүй үзэл, эх оронч сэтгэлийг өөрийн эрхгүй сэргээж, тэр нь сургаал ном, урлаг, уран зохиолд нь хүчтэй тусч, шашны сургууль, хүрээ хийдүүдийг дагасан суурин амьдралын өвөрмөц хэвшлүүд ч гарч иржээ. Нөгөө талдаа бурхны шашны дахин дэлгэрлийг даган монголчуудын эрдэм мэдлэг өргөжиж, соёл, утга зохиол, урлаг, гадаад харилцаа өргөжин, хятад, энэтхэг, төвд, манж, араб, персийн соёлын үнэт зүйлс ч нэвтрэн орж, “Ганжуур”, “Данжуур” их хөлгөн бүтээлүүд орчуулагдаж, “Гучин зургаатын тайлбар толь” зэрэг олон зуун дуун хөрвүүлэг, хэл шинжээч эрдэмтдийн хүчийг дайчилсан аварга бүтээлүүд барлагдаж, эртний түүх-уран зохиолын эрхи, товчоонууд олны хүртээл болон уран цутгамалч /бурханч/ Г.Занабазар алдарт 21 дарь эх, “Жанлав Цогзол” гүн ухааны шүлэглэл, соёмбо үсэг зохиож, ойрдын Огторгуйн далай Намхайжамц тод үсэг зохион, бурхан шашны уран барилгын хэлбэр /Гандантэгчилэн, Амарбаясгалант хийд/ зохиомжид үндэсний урлагийн дэг барил гүнзгийрч / бурхны шашны урлалын хатуу дэгийг эвдэн баримлын урлагт шинэчлэл хийж, монгол урлаг соёлыг сэргээсэн гэж үздэг/ байсныг судлаачид хэдүйн тогтоожээ. Монголын соёл урлагт гарсан сэргэн мандалтын үйл явц үндсэндээ XVII-XVIII зууны бодот ололт, шинэ үеийн баримт судалгааны бүтээлээр батлагдахын зэрэгцээ өөрийн үндэсний өвөрмөц онцлогтойг дурдах учиртай. Монголын сэргэн мандалт харийн колоничлолын эсрэг эх оронч үзэл санаа, тэмцлийн түүхтэй нөхцөлдөн гарсан бөгөөд Цахарын Лигдэн хаан /1630-аад он/ халхын Цогт хун тайж, Ойрдын Галдан бошигт нараас Манжийн ноёрхол, шарын шашны эсрэг явуулсан тэмцэл, нийт ард иргэдийн эх оронч үзэл санааны сэргэлт, улс үндсээ хамгаалах үзэл санаа халхын ноёд төдийгүй ардын сэтгэлд шинэ үзэл санаа бүрэлдэхэд чухал үүрэгтэй байв. Унгарын эрдэмтэн Д.Кара “Энэ хатуу, хэмжээлшгүй зовлон зүдгүүрийн зуунд л чухамхүү монголчуудын соёлын амьдралд сэргэн мандалт тохиолдсон байна” /3.36/ гэж “XVII-XVIII зууны монголын соёлын сэргэн мандалт” бүлэгт тодорхойлсон нь бидний санааг улам итгэлтэй болгож байна. Гэхдээ Д.Кара Европын соён гэгээрүүлэгчдийн үед монголын сэргэн мандалт эхэлсэн тухай санаанд зарим талаараа шүүмжлэлтэй хандах хэрэгтэй юм. Учир нь Европын сэргэн мандлын зөвхөн феодалын ёсыг эсэргүүцсэн шинэ хөрөнгөтний хөдөлгөөн ба хүний биеийн болон оюуны харанхуй байдал, дарлалаас чөлөөлж, шашны боолчлолыг эсэргүүцэх хөдөлгөөнтэй холбон үзэж, анхнаасаа эртний Грек, Ромын соёл суртахууны өв залгамжлалыг сэргээн мандуулах зорилго бүхий XV-XVI зууны үетэй шууд адилтгасан явдал юм. Өөрөөр хэлбэл европ төвийн үзэл хүчтэй болсон үеийн эрдэмтдийн үзэл уг бүтээлд бий. Үнэндээ Европын сэргэн мандал нь Дорно дахины ард түмний соёлын сэргэн мандалтын үеүд хоорондоо он цагийн хувьд ойролцоо юм. Магадгүй Дорны соёлын нөлөө өрнөдийн соёлын сэргэн мандалд чухал үүрэг гүйцэтгэсэн тухай үзэл магадлалтай ч байж мэднэ. Академич Н.П.Конрад Хятадын Тан, Мин улсын үеийн соёлын сэргэн мандалтын тухай өгүүлсэн нь бүр VIII-X зуун,

магадгүй XV-XVI зууны Европын сэргэн мандалтаас өмнө дорно зүгт сэргэн мандал эхэлсэн байхыг үгүйсгэх аргагүй. Европын улс орнуудын соёл, урлаг, утга зохиолын сэргэлтийн түүх тухайлбал, XIV зуунд хүнлэг энэрэнгүй үзлийн урлаг уран зохиолууд гарч тэдгээрийн үзэл санааны чиглэл нь /Данте, Петрарка, Боккаччо г.м/ тархай бутархай асан Итали орныг нэгтгэх феодал язгууртны хоорондын дайн дажинг зогсоох эрмэлзлэл бүхий эх оронч үзэл санаа илэрхий бөгөөд мухар сүсэг, мунхарлаас ангижруулах зорилт хүчжиж, Францад Ф.Рабле XV-XVI зуунд хөрөнгөтний шинэ харилцаа өргөжиж ирэхийн зэрэгцээ хүчирхэг хэмжээгүй эрхт хааны захиргаан дор тархай бутархай улсаа нэгтгэхийг уриалж сэргэн мандлын үндсийг тавьсан гэж үздэг бөгөөд эзэн хаан ч шашны эсрэг хөдөлгөөн, шинэ соёлыг ивээн дэмжиж байсан нь шинэ соёл, шинжлэх ухаан, урлаг, уран зохиолын сэргэлтэд маш их дэмжлэг болсон ч аажмаар улс орны дотоодод шинэ үзэл санаа хүчтэй дэлгэрэхийн хэрээр хааны харгислал эхэлжээ. Английн сэргэн мандалт мөн л монголчуудын нэгэн адил феодалын байгууллын гүнд бүрэлдсэн бөгөөд хүнлэг энэрэнгүй үзэл, соёл суртахуун XVI-XVII зуунд эрчимтэй хөгжжээ. Английн сэргэн мандлын үеийн уран зохиол /Т.Мор, В.Шекспир/ нь зөвхөн феодалын ёс, шашныг эсэргүүцсэн бус, хөрөнгөт ёсыг эсэргүүцэж, ард олноо дарлал мөлжлөгөөс чөлөөлөх туйлын хүслэнг урлагт дэвшүүлэн тавьж байжээ. Испанийн сэргэн мандалт Англичуудтай ойролцоо XV-XVII зуунд цэцэглэн хөгжсөн ч өөрийн онцлогтой байв. Харин Испанид хэмжээгүй эрхт ёсны ноёрхлын үед сэргэн мандалт эхэлсэн байна. Колонийн эзэн орны хувьд гадаадын хямд баялагт түшиглэж байсан тул дотоодын гар урлал, үйлдвэрлэл огт хөгжөөгүй орон байж. Харин арабуудаас газар нутгаа чөлөөлөхийн төлөөх олон зуун жилийн тэмцлийн явцад сэргэн мандлын үйл явц бэлтгэгдсэн онцлогтой. Нийгэм түүхийн байдал, үүссэн нөхцөл байдлын хувьд монголын соёлын сэргэн мандлын гадаад, дотоод нөхцөл байдал, хүчин зүйлтэй нэлээд төстэй юм. Түүгээр ч барахгүй Испанийн сэргэн мандлын үеийн соёл, уран зохиолд Европын бусад орны сэргэн мандалтаас нэлээд өөр байж. Энэ үеийн соёл, уран зохиолд нэг талаас феодалын үзэл суртлын бат бэх уламжлал, язгууртны алдар хүндийг шүтэх, шашны сургаал номлолын сэдвийг голлон хөгжүүлэхийг чармайж байсан ч нөгөө талаас иргэний ардчилсан дэвшилт үзэл санаанд суурилсан уран зохиол, урлагийн бүтээлийг хүссэн, бие, оюун санааны эрх чөлөөтэй байх ёстойг ухамсарласан ард түмний эсэргүүцэл энэ үед хүнлэг энэрэнгүй үзлийн урлаг, уран зохиол хөгжих таатай нөхцөл бүрдүүлсэн нь монголын сэргэн мандлын туулсан замналтай ойролцоо байна. Иймд сэргэн мандалт зөвхөн феодализм ба шашны эсрэг чиглэж шинэ хөрөнгөтний харьцааг зайлшгүй талархсан байх ёстой гэсэн үхширмэл онолын ойлголтоор хэмжих боломжгүй юм. Үндэстэн бүрд өөрийн сэргэн мандалт өөр өөрийн хэв төрхөөр ондоо ондоо цаг, урт богино хугацаанд тохиолддог /М.дө Сервантес/ том цар хүрээг хамарсан дэвшил, шинэчлэх үйл явц гэж үзэх ёстой. Ф.Энгельс сэргэн мандлын үеийг *“Хүн төрөлхтний үзэж өнгөрүүлсэн бүх эргэлтийн дороос нэн агуу дэвшилт эргэлт”* /4.4/ гэж үнэлсэн билээ.

Үүнээс XVII-XVIII зууны үе, монголын үе үеийн эрдэмтэд, зохиолч, соёл урлагийн зүтгэлтэн, түүхч нарын анхаарлыг гойд татах төдийгүй, соёл урлаг уран зохиолын хөгжлийн бүхэл нэг үе болж судлагддаг нь санамсаргүй хэрэг биш. *“Монголын уран зохиолын тойм”*-ын II боть бүхэлдээ академич Д.Цэрэнсодномын *“Монголын уран зохиол”* /1987/-ын нэгэн бүлэг, Г.И.Михайлов, К.Яцковская нарын *“Монгольская литература”* /1975/ зэрэг судалгааны бүтээлд энэ үеийг тусгайлан хам хүрээ болгон үзэж, *“үндэсний ухамсрын сэргэлт”* /5.263/-тэй холбосон нь зөв юм.

Дорно дахины улс үндэстний соёлын сэргэн мандалтын үеийн талаар, ялангуяа Япон, Хятад, Энэтхэгийн сэргэн мандлын үеийг судлан тодорхойлох чиглэлд Орос ба Европын харьцуулсан уран зохиол судлалын нэртэй эрдэмтэд 1960-аад оноос их анхаарч, тухайн үндэстний судлаачид өөрийн урлаг утга зохиолын судалгаандаа сэргэн мандлын үеийг онцлон үзэх болжээ. Тухайлбал, дундад Азийн судлалтан В.А.Чалоян *“Арманы сэргэн мандалт”* /1963/, академич В.М.Штейн *“Хятад, Японы түүх, хэл шинжлэл”* /1961/ харьцуулсан судалгаа, И.С.Брагинский *“Дорно дахины судлалын асуудлууд”*, /1974/ академич Н.П.Конрад *“Өрнө, Дорно”* /1966/, профессор Д.Кара *“Монголын нүүдэлчдийн номууд”* /М., 1972/ бүтээлдээ соёлын сэргэн мандалтын үеийг тодорхойлон тогтоохыг эрмэлзэж иржээ. Доктор Ч.Билэгсайхан дээрх өгүүлэлдээ монголын сэргэн мандалтын үеийн уран зохиолын хөгжлийн асуудлыг нэлээд ултай судалж сонирхолтой баримт жишээгээр үзүүлсэн ч *“гуманист чиглэлийг тодруулах хэрэгтэй болжээ”*, *“монголын уран зохиолын сэргэн мандалтын үеийн уран бүтээлийн аргын талаар нарийвчлан судлах явдал чухал болжээ”*/мөн тэнд/ зэргээр бусдад даатгасан, эргэлзсэн, эсвэл өрнө дахины сэргэн мандлаас ялгарч буй онцлогийг тэр бүр гаргаагүй ч монголын сэргэн мандлын үеийг тодорхойлох анхны томоохон сэдэл санаа болсон юм.

Дэлхийн янз бүрийн бүсэд хамаарах улс орны соёлын сэргэн мандлын үеийн түүхийг үзэхүл хэд хэдэн ерөнхий хэв шинжээр нэгдмэл байна. Үүнд а/ феодалын эзэрхэг ёс, шашны схоластика сургаал, сүсэг бишрэлийн эсрэг хүнийг өргөмжлөн /эрхэмлэх/ шинэ үзэл санаа дээдлэх, б/ хүнлэг энэрэнгүй үзэл, хүнийг нийгмийн болон оюун санааны дарлалаас чөлөөлөх үзэл санааг дэмжих, в/ шинэ үзэл санаа бүхий энэрэнгүй үзэлтэй, олон талын авъяас билигт сэтгэгч, уран бүтээлчдийн /сэхээтний давхарга/ бүхэл үе нийгмийн тавцнаа гарч ирэх, г/ эх оронч үзлийн дэлгэрэл, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дэмжих, д/ улс орны дотоодын хагарал, бутрал, ангиудын хоорондын зөрчил тэмцлийг зохицуулах, нэгтгэх дэвшилтэт үзэл санаа, е/үндэсний соёл, ёс суртал, уламжлал, үндэсний ухамсрыг сэргээх, шинэ соёл, шинжлэх ухааны мэдлэгийг дэлгэрүүлэх, ё/ нийгмийн гэгээлэг хэсгийн үйл хэрэг, хүсэл зорилгыг уран зохиолд бодтой тусгах зэрэг харилцан нэг нь нөгөөгөөсөө шалтгаалан гардаг олон хүчин зүйлс тухайн үндэстний соёлын сэргэн мандлын үндэс суурь болдог. Энэхүү сэргэн мандлын гэх бүх ололт амжилтад дөрөөлөн, XIX зууны дунд үеэс XX зууны 40-өөд оныг хүртэлх үед үндэсний онцлог бүхий соён гэгээрүүлэх үеийг туулсан гэх бодол аяндаа төрдөг юм.

Ийн тодорхойлох шинж тэмдгүүд монголын уран зохиолын түүхийн баримтаар нотлогддог. Энэ тухайд эрдэмтэд тайлбарласан тул давтахаас түдгэлзэж, харин бусад үндэстний сэргэн мандлаас монголын соёлын сэргэн мандалт юугаараа өөр байсан гэдгийг дараах хэдэн зүйлээр тайлбарлаж болох юм.

1. Дорно дахинд аж ахуй, амьдралын хэв маяг, хэвшил, буддын шашны нөлөө, дэлхийн колоничлолтой холбоотой феодалын байгуулал өрнө дахинтай харьцуулбал маш удаан үргэлжилжээ. Ялангуяа монголчуудын хувьд нүүдлийн мал аж ахуйн хэвшил хийгээд гар урлал бага хөгжсөн зэргээс шалтгаалан капитализм бэлтгэгдэж чадаагүй байв. Үүнтэй уялдан монголын соёлын сэргэн мандалт өрнөдийнхтэй адил капиталист байгуулал, хөрөнгөтний шинэ харилцааг хөгжүүлж, хүнийг феодалын хамжлагын хараат байдлаас чөлөөлөх, хөгжүүлэх үзэл санааны дор бус харин өөрийн улс үндсээ колоний дарлалаас чөлөөлөх үзэл санааны дор монголын соёлын сэргэн мандалт болсон бөгөөд ард түмнийхээ үндэсний ухамсрыг сэргээх бодлогыг төр

нийгэм, соёл, шашин, шинжлэхүй ухааны нэрт зүтгэлтнүүд оюуны соёлын бүх салбарт барьж, түүндээ шарын шашны дэвшилтэт зүйлсийг /ном хэвлэх, барлах, алс хол аялан бадарчлах, эрдэм ухаанд суралцаж, цол зэрэг хүртэж, сургаал номлол гаргах, хүрээ хийд байгуулж, бурхан шүтээний урлалыг хүний сайхан шинж, хүнлэг ёсны зүгт улам бүр татаж байв/ ашиглаж байжээ.

2. Манж–Хятадын колоничлолын эсрэг эхэн үедээ цэрэг зэвсгийн хүчээр биш оюун ухаан, уран туурвил, соёлын үнэт зүйлсээ хадгалан үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд олон түмнийг бэлтгэх үзэл санаа халхын яруу найрагч Цогтоос эхлээд Инжаннашийн *“Хөх судар”* хөлгөн бүтээлээр дамжин бэлтгэгдсэн байна.

3. Тэнгэр шүтлэгийн ёсноос шарын шашин руу шилжиж түүний дэвшилтэт талыг ашиглахын зэрэгцээ, дундад зууны хамжлагат ёсны суртахуун, хүлцэхүйн сургаал номлол үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний дэвшилтэт үзэл санаатай мөргөлдөж байв. Ийнхүү түүхийн өвөрмөц онцгой үе үндэсний ба гадаадын давхар дарлал, шарын шашны ид дэлгэрлийн үед монголчууд үндэс язгуураа хамгаалан үлдэхийн тулд оюуны соёл, урлаг уран зохиолын салбарт их анхаарал тавьснаар соёлын өвөрмөц онцлог бүхий сэргэн мандалтыг бий болгож чадсан байна. Сүүлийн үед судлаачид *“монголын урлаг соёлд XVII зууны үеэс тодорхой хэмжээгээр сэргэлт болж нэгэн шинэ үе эхэлсэн”* . . . *“дорно дахины хөрш зэргэлдээ орнуудын уран зохиолд сэргэн мандалт болсон... /6.75/ гэжээ. Ийм “учраас монголын уран зохиолд ч мөн энэ процесс болсон нь лавтай”, “Монголын уран зохиол өөрийн 800 орчим жилийн хөгжлийн явцад төв Ази, Алс дорнод, Өмнөд Сибирийн ард түмнүүдийн уран зохиолтой бүх талын харилцаатай хөгжжээ” /7.3/ зэргээр орос, монгол, унгарын монголч эрдэмтдийн хамтарсан томоохон бүтээлд дүгнэж, Төвд, Монгол, Энэтхэг, Алс дорнод, Сибирийн ард түмнүүдийн уран зохиолын харилцааны баялаг уламжлалыг нэлээд ултай судалжээ.*

XIX зууны II хагас гэхэд монголын уран зохиол улам бүр соён гэгээрүүлэх чиг хандлагатай, иргэний ардчилсан чиглэл хүчтэй болсон төлөв тод харагдана. Энэ үеийн уран зохиолд нийгмийн гарал, угсаа язгуур ялгавартай ч иргэний ардчилсан үзэл санааг зохиол бүтээлдээ тусгасан зохиолчдын бүхэл бүтэн үе төрж, тэдний зохиол бүтээл XIX-XX зууны эхний хагасыг хамарсан соён гэгээрүүллийн үеийн уран зохиолын иргэний чиглэлийг гүнзгийрүүлж, соён гэгээрүүллийн үзэл санааг илэрхийлсэн шүүмжлэлт реалист чиг хандлага гүнзгийрсэн байна. Үүний зэрэгцээ шашны уран зохиолын бие даасан чиглэл, иргэний ба шашин суртахууны холимог /нэгдмэл/ чиглэл хандлага ялгарч, уран бүтээлийн төрөл жанр, хэлбэрт багагүй өөрчлөлт гарсны дээр утга зохиол, уран зохиолын, аман ба бичгийн зохиолын ялгарал эрчимтэй явагдаж, уламжлалт реалист бус сэтгэлгээний хэв маяг, дүр, дүрслэлийн систем, хэв маягууд баяжин гүнзгийрч байв.

Монголын утга зохиол, түүх, урлаг соёлын салбарыг хамарсан сэргэн мандлын үйл явц, цаг үе өрнөдөөс ихээхэн өөр нөхцөл, өөр зам мөртэй байсныг XVII-XVIII зууны монголын нийгмийн түүх харуулах бөгөөд *“XVI зууны сүүл XVII зууны эхэн үеэр шарын шашин хүчтэй дэлгэрсэн нь манж чин улсын булаан эзлэгч нарт дарангуйлах зэвсэг болж байв. Энэхүү дарлал, мөлжлөг зөвхөн ард түмний дургүйцлийг хүргэж байсан төдийгүй ноёлогч ангийн зарим нэг эх оронч дэвшилтэд хүмүүст нөлөөлж тэдний эсрэг тэмцэхэд хүргэж байлаа”* . . . *“ялангуяа–улс үндэстнийхээ түүх бичих ажил энэ үед урьд урьдаас өрнөлттэй болсон нь. . . харийн дарлал, хавчлага ихсэх бүр үндэсний ухамсар сэргэн ирсний нэг гэрч”* /8.262-263/ зэргээр үзсэн дүгнэлтүүд ахмад, дунд үеийн судлаачдын томоохон бүтээлүүдэд олонтаа таарч байна.

Үндэстэн бүр өөрийн өвөрмөц онцлогтой ч бүс нутаг, хэл, соёл, шашин шүтлэгийн хувьд ойролцоо буюу ижил хэв маягтай байхын зэрэгцээ дэлхийн нийт улс түмний хөгжил, мандал буурлын үүх түүх нэлээд хэмжээгээр нийтлэг монголын уран зохиол, урлаг соёлын түүхэнд тохиолдсон сэргэлт нь өрнө дорны улс орнуудын урлаг соёлын сэргэн мандалттай ойролцоо үед тохиолдсон бол соён гэгээрүүлэл хийгээд шүүмжлэлт реализм, мөн европт дэлгэрсэн хэмээгдэх реалист бус арга, чиглэлүүд ч монголын уран зохиол, урлагт байсан нь *“маргаангүй” /9.86/ юм. Тэдгээрийн ул мөр эртний хэв төрх сонгодог бичгийн уран зохиол ба аман бүтээлд эх сууриа тавьж хөгжлийн түвэгтэй зам туулж иржээ. Академич Н.П.Конрад “өрнө дорнын уран зохиолын хөгжилд нийгмийн хөгжлийн түүхэн тодорхой үеүдэд адил үйл элбэг тохиолдож байна. Энэ нь дэлхий нийтийн уран зохиолын түгээмэл хууль, зүй тогтол бололтой” /10.419/ гээд өрнө дахины уран зохиолтой Хятад, Японы уран зохиолыг харьцуулан судлаж, сэргэн мандалт өрнөдөд бус дорнын улс үндэстнүүдэд анх гарсан гэж баталж байхад тэр нь цаашид өрнө зүгт дэлгэрэн тарахад Монголын зээнт гүрний үүрэг чухал байсныг дурьдсан эрдэмтэд ч бий. /Д.Капа/*

Бидний судалгаа монголын уран зохиол дахь реалист бус арга, чиглэлийн асуудлыг сонирхож байгаа учраас сэргэн мандлын реализм, соён гэгээрүүлэх реализм, шүүмжлэлт реализмын аргын тухай дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагагүй бөгөөд харин 1920-иод оноос хойш үеийн уран бүтээлийн арга зөвхөн реалист чиг хандлагатай байгаагүйг тодруулахад түрүү үеийн хөгжлийн чиг хандлага улбаа уламжлалыг товч боловч хөндөх хэрэгтэй байв. Мөн 1920-30-аад оны уран зохиолын хөгжлийн байдлыг тодорхойлоход чухал дэвсгэр болох монголын соён гэгээрүүлэх үе буюу шүүмжлэлт реализмын аргын асуудлыг цухас дурдах ёстой.

Дэлхийн уран зохиолын түүхээс үзвэл соён гэгээрүүллийн үе өрнө дахинд XVIII зуунд тохиолдсон гэдэг. Энэ үе үзэгдэл сэргэн мандлын үетэй маш нарийн дотоод холбоо хамааралтай юм. Өрнөдийн уран зохиолын түүхэнд соён гэгээрүүлэгчдийн үе чухал үүрэг гүйцэтгэж, тэдний үзэл суртлынх нь үндэс засгийн эрхэнд гарахаар тэмүүлж асан залуу хөрөнгөтний ашиг сонирхол байжээ. Феодалын улс төр, нийгмийн байгуулалт хуучирч, шинээр мэндэлсэн хөрөнгөт ёсны нийгэмлэг рүү шилжих үндсэн нөхцөлийг бүрэлдүүлсэн тул соён гэгээрүүлэгчдийн гол зорилго нь феодалын ёс дэглэмийг *“бүдүүлэг”* хэмээн хурц шүүмжилж, феодалын нийгмийн улс төрийн гол хэлбэр болох хаант засаглал, хэмжээгүй эрхт төр, шүүхийн хүнд суртлын аппарат, язгууртны хөрөнгөндөө эрдсэн сагсуу, бүдүүлэг байдал, эгэл хүний хөлс хүчийг мөлжигч чанарыг эсэргүүцэн, тэдний үзэл суртлын гол зэвсэг шашин, сүм хийд, философи, урлагийн хуучин хэв загварыг бүхэлд шинэчлэх, шинэ маягийн соёлын үндсийг тавихад оршиж байснаараа тухайн үедээ олон нийтийн дэмжлэгийг хүлээн, соён гэгээрүүлэгчид оюун санааны бүтээлч үүргийг өндөрт тавьж дарлах, дарлагдах ёсны хуучин суурь дээр ирээдүйн шинэ нийгмийг байгуулж, оюун ухаан ноёрхсон нийгэм гэж томъёолж байв. Тэдний гүн ухаан, ертөнцийг үзэх үзэл ерөнхийдөө материалист үзэлд тулгуурлаж байв. Иймээс тухайн үеийн урлагийн нэг гол аргыг соён гэгээрүүлэх реализм байсан гэж хожмын онолч-түүхчид үздэг байна.

Зарим монголч эрдэмтэд *“соён гэгээрүүлэгчдийн үе дорно дахины ихэнх оронд XIX-XX зууны эхээр тохиолдсон” /11.89/ гэж үзжээ. Монгол үндэсний өвөрмөц онцлог бүхий сэргэн мандлын халааг соён гэгээрүүлэл залгамжилж XIX зууны дунд үеэс манжийн дарлалын эсрэг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд дэвшилтэд феодал, бичгийн сэхээтний давхарга нэгдсэнээр ард олны бослого хөдөлгөөн ихэсч, зохион байгуулалтад*

орж, нийт улс орныг хамрах шинжтэй болж ирэхэд уран зохиолын салбарт дэвшилтэд үзэлтэй хүмүүс амьдарч буй нийгмийнхээ гэм дутагдлыг уудалж, шашин суртахуун, лам нар, нийгмийн хоцрогдлыг хурц шүүмжилсэн Д.Равжаагийн шүүмжлэлт шүлгүүд, В.Инжаннашийн түүхэн уран сайхны роман, хуульч Сандаг, Хайдав, Ишсамбуугийн ёгт, давхар утгаст шүлэг, үг ба яриа зохиолууд, Агваанхайдавын шашны эвдрэл, гажуудлыг ёгтлосон шүүмжлэлт уран өгүүллэг, иргэний байр сууриа илэрхийлсэн шүүмжлэлт уран нийтлэл, В.Гулиранс, В.Гүнначүгийн язгууртны орд өргөө, феодалын нийгмийн гэм хорыг оновчтой илэрхийлсэн уянгат шүлгүүд, Р.Хишигбат, ерөөлч Гэлэгбалсан, гүн Лувсандондов, Х.Гамал нарын эрх чөлөө, энх амгаланг мөрөөдсөн уянгал шүлэг, То ван, Гүнгийн зуугийн Ишданзанваанжил нарын иргэний шүлэг, сургаал нийгмийн шударга бус байдлыг ил тод шүүмжилж эхэлсэн байна.

Эрдэмтдийн “*XIX зуунаас эхэлж XX зууны эхний хориод жил хүртэл үргэлжилсэн*” “*соён гэгээрүүллийн үеийн уран бүтээлийн гол арга нь шүүмжлэлт реализм байсан*” /12.89/ гэх томъёоллуудыг гүнзгийрүүлэх шаардлагатай юм. Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн нь үнэндээ ийм соён гэгээрүүллийн үр дүнд эрчимжсэн билээ. Монгол зохиолч, яруу найрагчдын бүтээл XIX зууны дунд үеэс эхлэн нийгмийн гэм дутагдлыг хурц шүүмжлэн, харгис харалган байдлыг далд ёгтоор төдийгүй ил өгүүлж, эрх чөлөө, хүнлэг ёс, энэрэнгүй үзлийг дэмжсэн өнгө аясаар үлэмж баяжиж эгэл хүний амьдрал, дүр, сэтгэл санаа руу хандан улмаар нэвтэрч эхэлжээ. Гэхдээ монголын уран зохиол дахь соён гэгээрүүлэх чиг хандлага нийгэм, цаг үе, зорилгоороо өрнөдийн урлагийн гэгээрүүлэх чиглэлээс ялгаатай бөгөөд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд олон түмний оюун санаа, хүч чадлыг нэгтгэн зоригжуулах, хамжлагат нийгэм, шашны хүлцэхүйн суртал, олон түмний оюун санааны хоцрогдол, харанхуй байдлыг шүүмжлэн шинэ нийгэм, эрх чөлөө, хүнлэг ёсыг хүсч байсан боловч нийгмийн хөгжлийн түвшин, давхар мөлжлөг, шүтлэг, хоцрогдлын элдэв дарамтаас шалтгаалан ирээдүйн сонголтоо онож тодорхойлох нийгэм–түүхийн нөхцөл бүрдээгүй байснаас зорилго нь үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөөгөөр тодорхойлогдож байсан юм. Энэ үед монголын уран зохиолд иргэний, шашны, бөө мөргөлийн уран зохиолын чиглэлүүд зэрэгцэн хөгжихийн хамт соён гэгээрүүлэх реализм, шүүмжлэлт реализмын арга голлох байр сууринд гарч иржээ. Сэргэн мандлын чиглэл нь классицизмтэй, соён гэгээрүүллийн чиглэл нь романтизм, сентиментиалист арга барилтай нэгдмэл байсан шинж тэмдгүүд ч цөөнгүй тохиолдоно.

Бурханы шашны чиглэлийг баримтлагч их найрагч ноён хутагт Д.Равжаагийн уран бүтээлд шүүмжлэлт реализмын хэв шинж, соён гэгээрүүлэх үзэл санаа хурц илэрдэг. Тухайлбал: “*Ичиг ичиг*” шүлэг шүүмжлэн гэгээрүүлэх, засан тохинуулах үзэл нэвтэрхий бол “*Төрж өсгөсөн гөрөөс ээж*” шүлэгт энэрэн нигүүлсэх, хүний жудаг ёсыг эрхэмлэн дээдэлсэн утга тод юм. Нийгэм, улс төр, оюун санааны амьдралд бий болсон хямралт нөхцөл байдлыг шоглох, ухааруулан сайжруулах, энх амгалан эрх чөлөөг хүсэмжилсэн өнгө аяс нэвтэрхийн зэрэгцээ шашны номлолын харгис, хүлцэнгүй шинж, хуурмаг суртал нийгмийн оюун санаанд нөлөөлж буйд дургүйцэн урлагийг эгэл амьдралын үнэн рүү ойртуулахыг эрмэлзсэн шүлэглэлт зохиолууд олон гарч байж. Жишээ нь:

Там, там гэвч там хаанаас байх вэ

Тамтаггүй явбал там чинь тэр буй за

мөрүүдэд “*буг*”, “*бурхан*”, “*там*” гэдэг шашины оюун санааны хийсвэр зүйлсийн бодот мөн чанарыг,

Нанчид нанчид гэвч нарийн хар архи

Нарийвчлан шинжилбэл

Найман тамын нэг нь. . . зэргээр хүний эгэл амьдрал, бодот байдал руу татан оруулж сургаал, гэгээрлийн агуулгаар баяжуулсан бол “Зүйл зүйлийн үзэгдэл” дуундаа “*бурхан буг*”, “*буян хилэнц*” зэргийн түвэгтэй ойлголтыг бодот байдал руу татан

*Бурхан ч сэтгэлээс гарна
Буг ч сэтгэлээс бүтнэ
Буян хилэнц сэтгэлээс
Булт хоосон сэтгэлд буй*

зэргээр илтэд ухаарсан иргэний өнгө аяс, бодот агуулгаар баяжуулж өгсөн байна. Энэ мэт шашны сургаалын язгуур үзэл санааны эсрэг иргэний үзэл бодлоо илэрхийлсэн бүтээлүүд элбэгшиж, улмаар соён гэгээрүүлэлийн чухал шинжийн нэг болох үндэстний эв нэгдэл, ухаалаг амгалан амьдралын хүслэн түүний уран бүтээл гүнзгий шингэжээ. “Сэтгэлийг амраагч” сургаалдаа “*Жигүүргүй шувуу байдаггүйн адилаар ихэд ч эв хэрэгтэй, багад ч эв хэрэгтэй*” хэмээгээд нэг хоёр хүн байтугай, нийт улс үндэстэнд эв найртай байдал чухлыг

*Хоёр түшмэл эвтэй болбол
Хааныг ч бол чадах
Хоёр хаан эвтэй бол
Дайчин улс амгалан
Эвгүй хоёр хаан дайтаж байхад
Эвтэй өвгөн эмгэн хоёр нэгэн өвөртөө амраг хэвтэцгээнэ
Эвтэй хоёр хааны гүрэн амгалан байхад
Эвгүй хүү, хүүхэн хоёр нэг нэгнээ алалцах*

гэх зэргээр харшуулал, зүйрлэлийн ур маягуудыг ашиглан санаагаа улс төр, иргэний аясаар гүнзгийрүүлсэн бол цаг төр, амьдралын дотоод хамаарлыг “*Эд малгүй хүн үнэн үг хэлэвч хэрэглэхгүй цаг болжээ. Манж зангүй хүн ганцаардах цаг болжээ*” хэмээн халаглаж, тухайн цаг, улс төр, нийгмийн шударгагүй байдлыг ил шууд шүүмжлэн бичиж байв. Мөн “*Аврал гурван чухаг*” , “*Базардар*”, “*Ертөнц авгайн таалал*” зэрэг шашны агуулгатай зохиолд нь сентименталь сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзэл шингэсэн ажээ.

*Чин үнэн сэтгэл минь
Орчлонтой таардаггүй
Загнаж суух зан минь
Улсын номтой таардаггүй /Сэргэлэн зант цагаанаа. . . / хэмээн*

бичиж асан монголын шүүмжлэлт реализмын гарамгай төлөөлөгч Д.Равжаа уран бүтээлээ олон зүйл аргаар найруулан туурвиж байсан XIX зууны монголын феодал ангийн дотроос оюуны соёлын салбарт товойн гарсан томоохон уран бүтээлч байв. Түүний хүсэл мөрөөдлийг:

*Ноёлогдох албатгүй
Номхотгох дайсангүй
Нүүр харах өнгөгүй
Нэр заах оронгүй
Нээрээ сайхан жаргал*

бадгаар төлөөлүүлж болно. Д.Равжаа феодал ангийн төлөөлөгч хэдий ч дэвшилтэт үзэл санаатай том соён гэгээрүүлэгч байв. Түүний бүтээлд олон янзын арга найруулга /сентименталь, романтик, хэлбэрдэх, түүгээр ч зогсохгүй декадент, абстракт

сэтгэлгээний хэв маягууд/ бүхий зохиолууд байдаг. Түүнээс шүүмжлэлт реалист арга найруулга голлож байжээ.

Судлаач Д.Цагаан *“Равжаа бол өөрийн ангийн хүрээ, явцуу ашиг сонирхлоос даван гарч нийгмийнхээ доторх аливаа гэм дутагдал, муу муухайг нийгмийн дэвшилт хүчинд ашигтайгаар шүүмжилсэн анхны зохиолчдын нэг”* /13.23/ гээд *“Феодал ангийн зарим дэвшилтэт хүмүүсийн дотор үндэсний тусгаар байдлаа хадгалж, соёл боловсролоо хөгжүүлэн, өрнүүлэх”*-ийн төлөө тэмцэгчид олон байсныг өөрийн түүх, соёлын өв уламжлалаас тодорхой харж болно. /14.21/

Д.Равжаагийн уран бүтээлийн өв, төрөл зүйл, сэдэв, зохиомж үзэл санаа агуулгыг судлаачид нэлээд судлаад харин арга найруулгын талыг төдий л хөндсөнгүй.

Монголын шүүмжлэлт реализмын өв санд *“үг”* зохиолын өвөрмөц хэлбэр хөгжжээ. Хуульч Сандаг, Л.Хайдав, хувилгаан Ишсамбуу... зэрэг олон зохиолчийн баялаг өв үлдсэн юм. Доктор Д.Ёндон *“үг нь агуулгынхаа хувьд гэмшин гомдоллосон, хошигнон шоглосон, ёгтлон шүүмжилсэн. . . олон талтай ч ”. . . алив дутагдал, хоцрогдлыг илрүүлэн шүүмжлэхэд хамгийн тохиромжтой уран сайхны арга тул шинэ цагт. . . дэлгэрэн хөгжих ирээдүйтэй”* /15.125-131/ гэснийг бодвол бие даасан төрөл жанр, *“уран сайхны арга”* гэж үзсэн бололтой. Энэ сонирхолтой дүгнэлт юм. Монголчууд аман ба бичгийн уран зохиолд С.Буяннэмэхийн *“далд утгат шүлэг”* ба *“хос утгат шүлэг буюу хоёр байдлыг давхарлан үзүүлсэн шүлэг”* /16.17/ нэлээд бөгөөд далд утгат шүлэг хийсвэрлэх /абстракт/, хос утгат шүлэг зөвхөн утга далдлан оньсогоглох бус дүрслэлийн хэлбэрийн давхацлаар утга салгах /формалист/ чиг хандлагатай арга юм. Жишээ нь Б.Ринчений *“Шар саран чавганц”*, Хуульч Сандагийн *“Тэжээсэн нохойн үг”* зэрэг нь ил ба далд хоёр утгаар ойлгож болох, олон тайлал хийж болох давхар шүлгүүд бөгөөд В.Инжаннашийн *“Удвал”*, *“Хараацай хулснаа охилохуй”* зэрэг шүлгийг *“Хоёр утгасыг цухуйлгасан шүлэг”* /17.505/ гэж үзэж байсан нь өдгөө үеийн залуу шүлэгчдийн бүтээлд ч уламжилжээ.

Нэг юмыг нөгөө нэг юмс үзэгдэлд шилжүүлж дүрслэх, эсвэл бодтойг хийсвэрлэн үндсэн утгаа далдлан нууж хийсвэр томъёололд шилжүүлэх хоёр зүйл реалист бус аргыг хэрэглэж иржээ. Эдгээр нь соён гэгээрүүллийн үе, шүүмжлэлт реализмын урлагт өргөн хэрэглэдэг аргууд юм.

Сандаг нарын /XIX зуун/ үеийн *“үг”* ба *“яриа”*-чид харийн дарлал, шашны үзэл суртал, феодалын ноёрхлын давхар дарлал дор цэцэн мэргэн ухаан сийлж ард олондоо үнэнийг хэлж нүдийг нээх, шүүмжлэн эсэргүүцэх аргаа утга, дүрс шилжүүлэн далдлах, ондоошуулах, хийсвэрлэх маягийн уран сайхны нэг аргыг нээсэн нь нэгэн шинэ *“урсгал”* байв. Үүний дотоод учир шалтгаан нь тухайн үед гадаадын дарлал дотоод хүчний хоорондын зөрчил тэмцэл ихэд хурцдаж, түүнийг даган урлагт хяналт хардлага үлэмж ихэссэнээс ил тод, илэрхий дэвшилтэт, хурц шүүмжлэлт зохиол, тэмцэгч баатруудыг дэвшүүлэн тавихад ард гаралт яруу найрагч, дэвшилтэт үзэлт ноёд түшмэл, хутагт санваартан нарт халтай тул тэд улс төрийн давхар утга бүхий дэвшилтэт үзэл бодлоо адуусан ба байгаль ертөнцийн юмс үзэгдлээр төлөөлүүлэн хос утгын аргаар *“үг”*, *“яриа”* зохиолоо туурвиж ард олны нүдийг нээж зовлон, хорсол зэвүүцлээ илэрхийлж байж. Үг зохиолд амьтад, өвс ургамал, элдэв амьгүй эд юмс баатар байдаг ч тэрхүү шүүмжлэлт ёгт хэлбэрийн цаана хүмүүсийн амьдрал, ихэс дээдсийн ичгүүргүй дээрэнгүй ёс, нийгмийн гүн эмгэнэл тээгдэж байдгаараа соён гэгээрүүллийн хуучин ёс суртал, шашин, дарлал мөлжлөг, харанхуй байдлын эсрэг чиглэсэн ёгт, далд, дэвшилт санаа нуугдаж байдаг. Иймээс *“үг”* зохиол агуулгын гүндээ нийгмийн харилцааны

бодот дүр төрхийг агуулж далдуур, өөр юмсийн өвөрмөц хэлбэрт шилжүүлэн илэрхийлдэг уран бүтээлийн реалист бус сэтгэлгээний арга болно. Судлаач Ц.Мөнх /18.83/ Б.Ринчен /19.38/ В.Хайссиг /20.35/ Д.Ёндон /21/ Д.Галбаатар /22/ зэрэг эрдэмтэд “үг” зохиолыг өвөрмөц “хэлбэр”, “арга”, “төрөл”, “зүйл”, “дууль” хэмээн үзэж дээрх уран бүтээлчдийн зохиолыг “ангит нийгмийн үеийн эгэл хүмүүсийн хүнд бэрх амьдралын дууль” /23.33/ гэсэн нь үүний баталгаа юм.

“Үрийн сайнаар ургаж, үндэсний муугаар ховхорч, эрэгний мухарт хэвтэж, элс сөлөнд хутгалдаж, эрх багачуудын наадам, ишиг хурганы тоглоом” /Салхинд хийссэн хамхуулын үг/, шөнөжин хотоо манаад өглөө өлбөлзөн орж ирэхэд нь өвдтөл цохиж гаргаад нүцгэн яс хаяж өгдөг /“Тэжээсэн нохойн үг”/ үелзсэн олон нөхөд цахилан одоход хоёр “борвигүй” болоод хойноос нь харж хоцрох /“Хажид орсон зээрийн үг”/, болон “Ботгоноос нь салгаж жинд хөлсөлсөн ингэний хэлсэн үг” зэрэг зохиолын хийсвэрлэгдсэн далд утга нь нийгмийн дарлал, шударга ёс бус, хамжлагат ёсны үеийн нийгмийн дүр зураг мөн. Иймээс “үг” нь хос утгын уламжлалт аргаар бүтсэн өвөрмөц хэлбэр бүхий монголын соён гэгээрүүлэх үеийн уран зохиолд зохицон төлөвшсөн нэгэн гол арга байжээ.

Хуульч Сандаг далд, хос утгаст зохиолоос гадна хамжлагат ёс, ихэс ноёд, түшмэд, хиа нарын гэм дутагдал, тухайн үеийн нийгмийн ил тод, эрс шууд шүүмжилсэн “Сайн муу түшмэл бичээч нарыг хэлсэн үг”, “Дал хэр настай Очир хиа хорин настай бүсгүйг жирэмсэн болгосныг хэлсэн үг” зохиолууд илтгэнэ.

Тэр:

“Ухааныхаа хэрийг мэдэхгүй

Орны өндрийг түшиж

Ойр холоос бараалхах

Улсын учрыг ололгүй

Оволхийлж өөрийн хэрийг

Мэдэгч бичээч нар хөөрхий /“Сайн муу бичээч нарын хэлсэн үг”/

гэх хэмээн бичсэн нь нийгмийн шударга шүүмжлэл, реалист хурц тод дүрслэл илэрхий байна. Өрнө, дорны уран зохиолын хөгжлийн түүхийг үзэхүл нийгмийн хурц шүүмжлэл урлагаар дамжин бодот амьдралд хэрэгждэг соён гэгээрүүллийн үзэл санаа энэ мэт монгол уран зохиолд ч маш тодорхой хадгалагдсаныг Инжаннашийн “Хөх судар”, “Нэгэн давхар асар”, “Улаанаа охилох танхим” роман, сул шүлэглэл, найраглалаар батлагддаг.

Хятад эрдэмтэд Инжаннашийн романыг “шүүмжлэлт ахуйч үзлийн бүтээл болно” /24/, оросын эрдэмтэн Л.Г.Скородумова, монголын судлагч Г.Жамсранжав болон бусад эрдэмтдийн санаа нэгдмэл байна. Инжаннашийн “Чулуун дэрийн шүүмжлэл”, “Уг язгуураа мэдэж болохгүй”, “Номын хуурмаг”, “Үзэл санааг нь мэдэв”, ханбо Агваанхайдавын “Захиа бичиг”, “Чөтгөрт хөтлөгдсөн мунхагуудыг талхлан тээрэмдэгч аянгийн хүрдэн” зэрэг уран нийтлэлийн зохиолуудад харийн дарлал /эрх чөлөөг хүсэх/ хутагт хувилгаад /шашин/, феодал язгууртны нийгмийн дотоод мөн чанар хэрцгий дээрэнгүй байдлыг эрс шүүмжлэн эсэргүүцсэн нь ард иргэнийг гэгээрүүлэх үзэл санааны илэрхийлэл төдийгүй монголын уран зохиол дахь соён гэгээрүүллийн үе, шүүмжлэлт реализмын хөгжлийн явц цар хүрээг тодорхойлж байна. Энэчлэн В.Гүлиранс /1920-1951/, Ишданзанваанжил /1854-1905/, С.Лувсандондов /1854-1909/, Х.Гамал /1871-1932/, Агваанхайдав /1779-1838/, Р.Хишигбат /1849-1916/, Дорж мэйрэн, Шагдар зэрэг XIX ба XX зууны эхэн үед хамрах томоохон зохиолч, яруу найрагчдын

бүтээл дэх шүүмжлэлт реализм, романтик өнгө аяс, соён гэгээрүүлэх үзэл санаа, утга далдлах, болзолт дүр ашиглах, хийсвэрлэх хэлбэрийн эрэл хайгуул хийсэн бүхий л туршлага нь XX зууны эхэн үеийн зохиолчдын бүтээлд гүнзгийрч уламжлагдсан билээ.

XX зууны эхний хориод жилд ардын дунд зохиогдсон шог дуунуудад ч соён гэгээрүүлэл, шүүмжлэлт аяс, романтик тэмүүлэл тусгалаа олж байв.

Замбуутивийг ч жанжлахыг санасан

Зальхай амбан зайлаа биз ээ хөө

Богц богц мөнгөөр

Богдыгоо худалдсан сайдууд гуай

Хүүдий хүүдий мөнгөөр

Хүрээгээ худалдсан сайдууд гуай

зэрэг зохиогчтой, зохиогчгүй хурц шүүмжлэлт агуулга бүхий дуу шүлэг олноор гарч ард нийтийн үндэсний ухамсрын сэргэлтэд чухал нөлөө үзүүлж байв.

Ч.Билигсайхан XX зууны эхний хориод жилд бүтээлээ туурвисан зохиолч, яруу найрагчдын бүтээлийг цуглуулан судалснаас үзэхэд соён гэгээрүүлэх үзэл санаа, Манжхятадын дарлалаас салсан /1911 он/-ны дараа дотоодын хар, шар феодал, баяд ноёдын нүүр царайг илчилсэн, ирээдүйг мөрөөдсөн өнгө аястай шүүмжлэлт реалист үзэл-туурвил зүй гүнзгийрсэн гэжээ. Ө.Лувсан хуурч /1885-1943/, Д.Бодоо /1885-1922/, Ц.Жамсран, А.Амар зэрэг үндэсний сэхээтэн, ардын хувьсгалын эхэн үед хамрах нэлээд зохиолчдын /С.Буяннэмэх, Ши.Аюуш, Д.Нацагдорж, М.Ядамсүрэн... гм/ бүтээлийг судлаад: “энэ үеийн /XIX-XX зууны 20-иод. Д.Г/ урлан бүтээх арга нь гэгээрүүлэх амьсгаатай шүүмжлэлт реализмын арга байсан бололтой” /25.94/ гэжээ. Бидний үзлээр Монголын нийгмийн өвөрмөц онцлогтой уялдан XIX-XX зууны 40-өөд оныг хүртэл соён гэгээрүүлэх, суртал ухуулах, хуучин байдлыг шүүмжлэх хэд хэдэн томоохон чиглэл ялгаран, бичгийн уран зохиолд шүүмжлэлт реалист аргыг голлох байрнаа гарчээ. Үүний уламжлал 1950-60, 1980-90-ээд оны зааг үеийн уран зохиолд ч үе үе хүчтэй илэрч байсныг ч үгүйсгэх аргагүй.

Өрнийхэн соён гэгээрүүлэх хөдөлгөөний үеийн уран бүтээлийн аргыг соён гэгээрүүлэх реализм байсан гэж үздэг. Монгол уран зохиол бүрэлдсэн соён гэгээрүүлэх үзэл санаа дан ганц реализмын аргаар хязгаарлагдахгүй соён гэгээрүүлэх, ухуулан сэнхрүүлэх үйл ажиллагаандаа натурализм, сентиментализмын гэж болох арга найруулга, дүр дүрслэл, мөн “хэлбэр” /формаль/-ийн болон хийсвэрлэх /абстракт/ хэв маягийн аргуудыг чөлөөтэй ашиглаж байсан юм. Өрний шүүмжлэлт реализм нь романтизмын оргил үе дээр төлөвшсөн билээ. Монгол романтизм европынх шиг ямар нэг үзэл онол, дэг сургуулийн хатуу тогтоосон тааллаар бус бүр эртний аман ба бичгийн уран зохиолд эх үүсгэлээ тавьж хөгжлийн явцдаа монголын гэх өнгө төрх бүхий аргуудыг бий болгосон онцлогтой бөгөөд ялангуяа нийтийн нэр томъёогоор сентиментализм, романтизм, абстракционизмын уран сэтгэлгээний арвин баялаг туршлагыг бий болгож чаджээ. Монголын ард түмний туйлын хүслэн, сайн сайхан амьдралын мөрөөдөл тэмүүлэл, ардын дуу, шидэт үлгэр, их туульсын бүтээл төдийгүй ерөөл магтаалын арвин баялаг сан хөмрөгийг бүрэлдүүлж чадсан юм. Академич П.Хорлоо “Ардын аман зохиолын арвин их булгаас үндэслэн бий болгосон бичгийн утга зохиол бол манай ард түмний соёлын өвийн нэг том хэсэг нь мөн” /26.136/ гэжээ. Ардын аман зохиолос уламжлал аваагүй бичгийн уран зохиолын нэг ч төрөл, нэг ч арга найруулга үгүй нь үнэн юм.

Монгол ардын үлгэр монголчуудын аж төрөл, сэтгэлгээ, зан суртахуун, оюун билэг, сайн сайхан, шударга ёсны илэрхийлэл, ирээдүйн хүсэл мөрөөдөл нь байж нийгмийн зөрчил, дарлалыг ил далдаар ёгтлон харуулж, ерөөл нь бэлгэ дэмбэрэл, туйлын хүслэнг, магтаал нь аз жаргалант амьдралын дуулал бөгөөд тэдгээрт үндэсний зан үйл, амьдрал ахуйтай нягт холбогдсон амьдрал гэрэл гэгээ илэрч, анхааруулга сургамж, сайн сайхны бэлгэдлийг нийлэгшүүлсэн зүйр цэцэн үгс, тэнхээ, хурд хүчний төгс цогцлолын мөрөөдөл болсон “*бөхийн цол*”, “*морины цол*” г.м/ зэрэг нь цөм өөр өөрийн онцлог дүр дүрслэгдэхүүнтэй ч бүтсэн арга, ертөнцийг үзэх үзэл, хүсэл мөрөөдөл, дүрд бүрдсэн хэв шинж, уран сэтгэмжийн байдлаараа монгол үндэсний романтизмын илэрхийлэл болно. Монголчуудын аман уран бүтээл ардын засгийн үеийг хүрч иртлээ эн тэнцүү хөгжиж, аман зохиол нь бичгийн уран зохиол, бичгийн зохиол нь аман уран зохиол болж хувирах үзэгдэл тасралтгүй үргэлжилж ирсэн XX зууны цөөхөн үндэстний нэг мөн.

Европын бичгийн уран зохиол лугаа уран бүтээлийн нэг арга нөгөөг халж солих, тодорхой дарааллаар эхэлж, бас үеэ өнгөрөөх үзэгдэл монгол бичгийн уран зохиолд гараагүй бөгөөд нийтлэг, олон ургальч шинжтэй, цагийн жамыг дагаж урсгалаар зохицож хөгжсөн онцлогтой. Шүүмжлэлт реализмын өмнө заавал романтизм хөгжиж байх ёстой гэх үзэл нь зээлдмэл ойлголт бөгөөд өрнөдийн уран зохиолын хөгжлийн онцлог зүй тогтлыг монгол уран зохиолын жам ёсны хөгжлийн онцлогт тааруулах гэсэн оролдлого болно. Монголчуудын эртнээс өөрийн уламжлалт романтизм, символизм, сентиментализмын өвөрмөц хэлбэршилтэй, монгол аман ба бичгийн уран зохиолын аль алинд эрх тэгш хөгжиж ирсэн гэж ойлгож байна.

Монголын орчин үеийн уран зохиол үүсч хөгжих хамгийн таатай хөрс ойрын уламжлал нь XIX-XX зууны эхэн үеийн аман ба бичгийн уран зохиолын уламжлал байв.

Өрнөдийн уран зохиолд романтизмыг хүмүүсийн сайн сайхан, ирээдүйд итгэж, аливааг өөдрөг бадрангуй, гэрэл гэгээтэй сэтгэлээр харах /капитализмын шинэ байгуулал/ болсон үетэй холбодог. Гэвч Европын хувьд энэ сэтгэл зүй, хүсэн хүлээсэн мөрөөдөл тун удалгүй капитализмын хатуу хууль, чанар олон нийтэд танигдаж эхэлмэгц түүнийг эсэргүүцсэн олон түмэн ядуусын тэмцлийг илэрхийлэх чиг хандлагаар тодорхойлогддог. Гэтэл нүүдлийн соёл иргэншилтэй монголчуудад ийм завсрын үе шат /нийгмийн байгуулал/-ны үүдэнд тулж ирсэн эгзэгтэй үед их анд Оросын социализмын шинэ хувилбар түрэн орж иржээ. Ийм учраас монгол үндэсний аман ба бичгийн уран зохиолд реалист бус чиг хандлагууд уран сайхны дүр, дүрслэл, элементийн түвшинд хөгжиж асан романтизм ардын хувьсгалын дараах жилүүдэд идэвхжиж, цаашдаа үзэл сурталжсан соцреализмын шинэ аргатай нийлэгшиж эхэлсэн байна.

Нөгөө талаар их Юаний ноёрхол нурж, эзэнт гүрний эрх сүр буурах үетэй давхцан гуниг цөхрөл, хэсүүчлэлийн зохиол, сентименталь аяс бүхий сэтгэгдлийн, улмаар шашин ба феодалын дарлал мөлжлөгт дургүйцсэн өнгө аяс гүнзгийрч, ялангуяа Манж Чин улсын дарлалын үед хамаарах уран зохиолд тодорч, улмаар 1930-40-өөд оны үеийн уран зохиолд ч мэдрэгдэж байжээ. Монгол символизм, сентименталист арга, найруулга нь эртний аман зохиолоос эх үндэстэй бөгөөд түүний уламжлал одоо ч тасраагүй байна. Ханбо Агваанхайдавын “*Үхэр, хонь, ямаа гурвын яриа*”, “*Урт үст Цэрэнпил хэмээх бандитай тэмцсэн үг*” болон “*Чөтгөрт хөтлөгдсөн мунхагуудыг талхлан тээрэмдэгч аянгын хүрд*” болон “*Цогтын хадны шүлэг*”, Д.Равжаагийн “*Ичиг, ичиг*”, Хуульч Сандагийн “*Сайн муу бичээч нарыг хэлсэн нь*” зэрэг алдартай бүтээлийг судлаачид

зөвхөн “шүүмжлэлт реализм”-ын гэж итгэлгүйхэн тодорхойлж байна. Шүүмжлэл сэтгэлгээний уран зохиолд нийгмийн бурангуй ёс, байдалд дургүйцэж, улмаар засан сайжруулах, өөрчлөх боломжгүйд цөхөрсөн өнгө аястай нь феодал, шашны бурангуй ёс дэглэмийг эсэргүүцсэн сентименталь үзэл санаа, туурвил зүйн хэв төрхтэй юм.

Монгол уран зохиолын баримтаас үзвэл уран бүтээлийн аргыг зөвхөн феодализмын төгсгөл, капитализмын хөгжлийн үе шатуудтай холбон тайлбарладаг өрнөдийн уран зохиолын үечлэл нь тухайн бүс нутгийн хөгжил, соёл иргэншил, шашин суртахуунтай олон талаараа холбоотой төдийгүй монгол уран зохиолын аргын хөгжлийн түүхээс ялгаатайг илтгэдэг юм. Ийн монголын нийгэм, түүхэн хөгжлийн зам өрнөдөөс өөр тул монголчуудын бичиг зохиол, туурвил зүй, уран бүтээлийн арга ч өөрийн онцлогтой. Тиймээс ч зарим судлаач “Монголын уран зохиол, урлагт романтизм. . . бие даасан арга болж гарч ирэх нийгэм, түүхийн нөхцөл бүрдсэнгүй” /27.94/ гэж бичсэн нь таарна. Тэд “харин соён гэгээрүүлэх амьсгаатай шүүмжлэлт реализм нэлээд тодорхой төлөвшин хөгжсөн байна”, өрнөдийн уран зохиолд романтизмын дараа гарч ирсэн гэх шүүмжлэлт реализмын аргыг “зонхилох шинжтэй”- /мөн тэнд/ гэж дүгнэсэн нь нэлээд ташаа ойлголт билээ.

Бидний судалгаагаар XIX-XX зууны эхэн үед дээр өгүүлсэн янз бүрийн арга найруулгын ёс зэрэгцэн /холомог/ хөгжсөн байна. Харин үе үе тохиолддог нийгмийн хувьсгалт эргэлтүүдийн дараа романтизм, шүүмжлэлт реализм, символизм...зэрэг аргууд хүчтэй сэргэх үзэгдэл байдаг. 1920-1940-өөд оны монгол уран зохиолын баримтаас үзэхэд романтизм эхэн үедээ шүүмжлэлт реализмтай нэн ойртож, улмаар социалист реализм бүрэлдэн тогтоход уран сэтгэмжийн бадрангуй шинжээ даган түүнд шингэн уран сайхны талыг тэтгэхэд гол үүрэг гүйцэтгэсэн байна.

Судлаач Г.Жамсранжав “XX зууны 10-аад оны үеийн яруу найраг. . . сургаал үгс нь шинэ рүү тэмүүлсэн ардчилсан үзэлтэй, гэгээрүүлэх хүсэлтэй, шүүмжлэлт амьсгаатай” /28.251/ гэж үзжээ.

“Түмэнд мэргэн, буманд сэцэн гэж омгорхон гайхуулаад

Түмэн үеийн уламжлалт түүх үсгээ эс мэдвэл

Төвд, Хятадын түмэн үсэгт мэргэжливч

Төрөл төөрсөн төрөлтөн болохоос өөрцгүй. . .” /29/

гэх юм уу, Д.Нацагдоржийн хувьсгал, байгалийн төгс төгөлдөр шинжийг танин мэдэх хүслэн, эрүүл энх, нийгэм–аж байдлын сэдэвт шүүмжлэлт /ухуулгын/ уянга туульсын зураглал, С.Буяннэмэхээс хуучирсан ёс дэглэмийг шүүмжилсэн шүлэглэл зэрэгт соён гэгээрүүлэл, шүүмжлэлт санаатай бодот ахуйн дүрслэл /реализм/-үүд голдуу нийгмийн хоцрогдол, үндэсний соёл боловсролыг сэргээн хөгжүүлэх, хувьсгалч шинэ ёсыг тогтоох, гэгээрэл боловсрол, хүнлэг бус явдлыг шүүмжилж, шударга ёсыг дээдлэх үзэл санаа хүчтэй илрэх бөгөөд бүр XIX зууны дунд үеийн яруу найрагчдын бүтээлд ч нийгмийн шударга ёсны уриа цуурай тод байсан билээ. Хутагт Д.Равжаа:

Аяа бас номыг сэтгэлтэйгээ нийлүүлсэнгүй мэргэд ичиг

Аяа бас албатаа алаглагч ноёд ичиг

Аяа бас номыг үл суран элдвийг сурагч банди нар ичиг

Аяа бас бясалгалыг бясалгахгүй над хэмээн бахирагч егүзэр нар ичиг /Д.Равжаа.

“Ичиг, ичиг”/ гэх ба,

Гүжир том лам мяндаг тушаалаар өлсгөлөн

Гүрэмч доромч лам өргөл барьцаар өлсгөлөн

Гүйж явдаг бадарчин хоол ундаар өлсгөлөн

Гуен хуар хүүхэн нөхөр ханиар өлсгөлөн /Д.Нацагдорж/

зэрэг XIX-XX зууны эхэн үеийн зохиолчдын уран бүтээлд нэг талаас нийгэм, иргэний шүүмжлэл, засан сайжруулах үзэл санаа, орчин ахуй, цаг үеийн бодот төрх хурц тусч, шинийг талархаж, шударга энэрэнгүй ёсыг хүсэмжлэх үзэл санаа гүнзгий туссан юм. Үүний зэрэгцээ тухайн үеийнхээ нийгмийн бурангуй, хоцрогдмол байдлыг шоглосон, мөнхүү гуниг гутралын аяс гүн нэвчсэн нь уламжлалт сентименталь, декеданс хандлагын тод жишээ юм. Ийн шинэ цагийн уран зохиол хөгжихөд XIX-XX зууны эхэн үеийн монгол уран зохиолын уламжлалт реалист, реалист бус аргууд үндсэн дэвсгэр, эх булаг нь болж, харин 1940-өөд оноос социалист реализмын үзэл санаанд шахагдан бүдгэрсэн гэж үзэх үндэслэл болно.

Алив үндэстний уран зохиолд соён гэгээрүүллийн үе янз бүрийн нөхцөлд тохиолдсоор ирсэн бөгөөд XIX-XX зууны эхэн хагаст Монголын урлаг, соёлд соён гэгээрүүлэл эрчимжсэн гэж үзэж болмоор байна.

П.Хорлоо “...нэг талаас манай үндэсний утга зохиолыг баяжуулсан ба нөгөө талаас утга зохиолын орчуулгыг ардчилсан хэлбэрт шилжүүлэх явдалд дэвшилтэт алхам болсон юм” /30.142/ гээд “энэ ахицтай уламжлалын дагуу XVIII-XIX зууны үед дорно дахины соёлтой улам ойртон танилцах зүгт утга зохиолын орчуулга чиглэгджээ” /мөн тэнд/ гээд Гаалийдаасын “Үүлэн зардас”, их хөлгөн “Данжуур” /225 боть/, “Ганжуур” /108 боть/ -ийг орчуулж, “Гурван улсын түүх”, “Мөрний харги”, “Тансан лам баруун этгээдэд зорчсоныг тэмдэглэсэн түүх”, “Эрт эдүгээгийн гайхамшигт үзэгдэл оршвой” зэрэг томоохон бүтээлийн орчуулгын нөлөөг онцолсон бол Г.Жамсранжав “XX зууны эхэн үеэр Европ тивийн уран зохиолоос орчуулах ажил идэвхжсэнийг” /31/ тус тус тэмдэглэсэн нь монголын соён гэгээрүүлэл, шүүмжлэлт реализмын хөгжлийн үеийг тодруулахад чухал баримт болох юм.

Үүнээс үзэхэд монголчуудын туурвил зүй, бичлэг сэтгэлгээний арга найруулга нь өрнөдийнх лугаа бодлого, дэг сургуулийн хэлбэрээр юм уу уриа тунхагаар гэнэт гарч ирдэггүй урсгалаар аядуу хийгддэг онцлогтой бололтой. Ямар ч туурвил бүтээлийн арга нь хөгжлийн оргил үедээ хүрээд үгүйсгэгдэж, түүхийн “хог” болон хаягддаггүй. Янз бүрийн аргууд бий болж, буурч, дахин сэргэж дараа үедээ удамшин үргэлжилж, мөнхөд шинэчлэгдэж байдаг зүй тогтолт үйл явц гэж болох юм. Чухам үүгээрээ өрнө дахинаас дорно дахины туурвил зүйн хувьсал, шинэтгэл эрс ялгардаг аж.

Монголын эртний бичгийн зохиолд реалист бус аргын уламжлал баялаг юм. Үүнийг “МНТ”, хуульч Сандагийн “үг”, “Жангар”, “Аргасан хорчийн домог” /XIII/, “Хув Нагварал” /XV/ -ын туужийн зарим нэг жишээг дурдвал “МНТ”-д абстракт /зайцуулан ондоочлох/, бэлгэдэл символ дүрслэл үлэмж бий бол бэлгэдэх /символизм Д.Г/ аргын элементүүд захаас аван тааралддаг тухай доктор Д.Цэдэв тодорхой өгүүлжээ. Үүний нэг нь утга далдлан хийсвэрлэх арга бөгөөд Тайчууд Есүхэйн хөвүүдийг өсөхийн цагт:

Хурганы үс гуужив

Төлөгний үс төлжив /79/ Ц.Дамдинсүрэн “МНТ”

хэмээн довтолгон ирэх буюу Есүхэй баатрыг Татарт хорлогдоход:

Цээлийн үс ширгэв

Цэгээн чулуу хагарах /72/ Ц.Дамдинсүрэн “МНТ”

шүлэглэлийг хэлэх нь үндсэн утгыг далдлан утга шилжүүлэн хийсвэрлэх арга бөгөөд давхар бэлгэдэл санаа /цээлийн үс-хамаг монгол, цэгээн чулуу Есүхэй баатар гм/ буйг болсон хэрэг явдалтай холбосноор хялбархан тайлах боломжтой аж. Мөн эхний шүлэгт Есүхэйн хөвүүд өсч буйг далд ёгт бэлгэдэл болгож, шууд бусаар таагүй хандаж

байгаагаа илтгэсэн байна. Мөн Есүхэй, хөвүүн Тэмүүжин хоёртой Дай сэцэн тааралдаад: “Есүхэй худ би энэ шөнө нэгэн зүүд зүүдлэв. Цагаан шонхор шувуу нар сар хоёрыг атган нисч ирээд миний гар дээр буув” гэж зүүдлэв гэсэн нь нэг талаас зүүд зөн совингоор /үл ухамсарлахуйн илэрц/ дамжуулж мэдэх, дохио мэдээлэл авах нэг зүйл реалист бус аргыг гайхалтай онож хэрэглэсэн бол “Дува сохор магнай дундаа ганц нүдтэй, гурван нүүдлийн газрыг харах”, “Алунгоо хатны домог”-т /21-р зүйл/ эргүй атал гурван хөвгүүн төрүүлсэнээ “Шөнө бүр цагаан шар хүн өрх томгоор гийгүүлэн орж. . . миний хэвлийг илэхэд түүний гэрэл хэвэлд шингэх бүлгээ. Тэр хүн гарах нар сарны хилээр шар нохой мэт шалбалзсаар гарч одно” гэж тайлбарлаж буй нь үнэхээр “Бурхан багийн мэндэлсэн тухай домгийн монгол хувилбар” /Г.Сүхбаатар/ “домог үлгэрийн ойлголттой холбоотой уран сайхны дүрслэл” /Д.Цэрэнсодном/ буюу бурхад, хутагт хувилгаан, хаад /Гэсэр мэргэн хаан хэрхэн яаж төрсөн лугаа/ бодисадва /“Ногоон дарь эхийн тууж”/-ийн Оюу нэрт хөвгүүний ер бусын хувилгаан чадал, төрсөн түүхийн дүрслэлтэй төсөө бүхий болзолт дүрслэл, арга маяг бүхэлдээ реалист бус юм.

Д.Цэдэв “МНТ”-ны тооны бэлгэдэл, хүний амьдралын гол мөчлөг, сав шим мандал, өнгө, зөн совин, хувцас, уран үгийн дүрийн бэлгэдлийг цогцолбороор судалж үг хэллэг тооны бэлгэдлийг нэлээд ултай тайлбарласан билээ. Энэ нь монгол бичгийн уран зохиолын реалист бус арга найруулга эрт үеэс уламжлалтайг нотолдог.

“Аргусан хорчийн домог” ч бүхэлдээ хийсвэрлэл /утга далдлахын/-ийн гайхамшигт жишээ мөн. Чингис хааныг Солонгодын Бух цагаан хааны Хулан саран гүнжтэй хээр хөдөөгүүр хуримлан удтал саатсанд Аргусан хуурч элчээр очиж далд битүү утгатай захидлыг хоёр дахь удаагаа лавшруулан

Сал модонд салбар шувуу өндөглөв гэлээ

Мөн сал модонд итгээж суусаар

Өндөг зулзагаа идэгдэв гэлээ

Хулст нууранд хун галуу өндөглөв гэлээ

Мөн хулсанд итгээж суусаар

Хулд муу шувуунд үүрээ эвдэгдэж. . . /хутагт эзэн минь гэгээндээ

айлд/ хэмээхэд түшмэл эс мэдэв гэж буй. Хаан өөрөө нууц утгыг нарийн тайлж нутаг усаа тэмцэж байгаа нь өөрийн оньсого мэт битүүлэг утгатай бөгөөд түүнийг их эзэн удтал бодож утгыг тайлах нь утга далдлал /абстракт/ дүрслэлийн түвшинд илэрч буй нь юм. Энэчлэн Хишигбатын шүлэг, “Хув Нагваралын тууж”, “Субашид”, “Рашааны дусал”, “Цагаан лянхуан баглаа” зэрэг үндэсний болон орчуулгын тайлбарт зохиолууд цугаар далд утгатай бүхий абстракт шүлэглэл билээ.

Хуульч Сандагийн уран бүтээлд натурализмын хэв маяг илүү хүчтэй илэрдэг. Үүнийг хүүхэд багачуудын уншлагад зориулсан засвартай зохиолоос нь олж үзэх боломжгүй юм. Учир нь олон зохиолыг нь цагийн аяс, үзэл суртлын нөлөөгөөр танан хасч хэвлүүлжээ. Академич П.Хорлоо Ленинград буй 1921 онд А.Бурдуковын цуглуулгаас /Завханаас олсон/ Сандагийн 17 зохиолыг хуулан авч “Ард түмэн, аман зохиол” /1985/ бүтээлдээ хэвлүүлсэн нь иргэний аяс, реалист уран тансаг дүрслэлтэйн хамт бодот байдлыг үйлдлыг зурагчлан буулгах аргыг ашиглажээ. Тухайлбал, “Шинэ үрээ азарганы хэлсэн нь” шүлэгт:

. . . Тагшны чинээ тээрхийтэй

Таван барим озгойгоо гозойлгоод

Бага сага байдсуудыг

Багтаж ядтал чихлээ /151-р тал/ гэх юм уу

“Бухын хэлсэн нь” шүлэгтээ

... Айлаган хураасан эмсүүдтэйгээ

Аятайхан ханилахыг бодож

Аагинд нь тултал шааваас

... Огол харайгаад эргэхэд нь

Олдсоноос гэж

Онгинд нь тултал шааваас. . . /152-р тал/

эдгээрийг натурализмын /биологизмын урсгал/ чиглэлд хамруулахаас илүү тайлбар үгүй. Ийм натураль деталчилсан дүрслэлийг “Нохойн хэлсэн нь”, “Оонын хэлсэн нь”, “Хурган хуцны хэлсэн нь” гэхчлэн олон шүлэгт буй. Иймэрхүү физиологийн үзэгдэл болох хуял тачаалын явдлыг нэг зүйл хуулан бичих арга бусад үндэстний эртний уран зохиолд элбэг. Эртний хятадын “Алтан бумбан дахь лишийн цэцэг буюу Зин Пин Мэй бичиг”-т “Хоёр биенээ зүтгэлэн тэмцсэн гал халуун тэмцэл хагацаж дуусаагүй мэт үргэлжилсээр л, байн байн шидэт эврийн үзүүрээс рашааны дусал цэцгийн дэлгэсэн цоморлигийн голд чим чим дуслахуй. . . Энхэр цагаан цээж нь түнхэлзэн амьсгаадаж. . .” гэх юм уу Инжаннашийн “Нэгэн давхар асар”, Гаалийдаасын “Үүлэн зардас”, Дандины “Зохист аялгууны толь”-ийн тайлбар шүлгээс олон жишээ татаж болно.

Иргэний уран зохиолд аман зохиолын баатрууд, хий санааны дүр, санаанд багтамгүй үйлдлүүд уламжлагдаж ид шидийн уран шийдэл, хүмүүн бусын амьтад дүрслэгдэх сэлт нь монгол уламжлалт реалист бус аргын тогтолцоог бүрдүүлдэг.

Монгол иргэний уран зохиолоос хэн хүний мэдэх хэдэн зохиолыг тоймлоход л орчин үеийн символизм, абстракционизм, натурализмын сэтгэлгээний хэв маяг тод харагдана. Яруу найраг, туульсын төрөлд сентименталь хандлага, сэтгэгдлийн яруу найргийн /импрессион/ хэлбэрүүд ч эртний уламжлалтай билээ. Ер нь монголчуудын уран сайхны соёл, сэтгэлгээ, туурвин бүтээхүйн үйл ажиллагаанд хэт бодотчлох, хэт хийсвэрлэх, хэлбэрдэхээс нэлээд зайлсхийн эдгээр ерөнхий аргын тун жорыг тааруулахад багагүй анхаарч байсан байна. Гэхдээ бодот байдлыг хуулж дуурайх бус уран сэтгэмж, болзолт дүр, дүрслэлийг шинээр зохион олж бодот зүйл мэт болгон дүрслэх чадвар илүү хөгжсөн гэж болно. Үүнийг “Жангар” туулийн 1012 баатрын нэг Баянхүнхээн Алтан Цээжийн эрдэм шид /ирсэн ерэн есөн жилийн хэрэг явдлыг тоолж хэлдэг, ирээгүй ерэн есөн жилийн явдлыг тааж мэддэг/ эсвэл тэнгэрээс ганц хуруу доогуур барьсан Жангарын Есөн өнгө алтан торлог орд, түүний тансаг хийц, хэлбэрээр төлөөлүүлж болно.

Монголын эртний уран зохиолын нэг том хэсэг нь бурханы шашны уран зохиол юм. Шашны уран зохиолыг судлах ажил 1921 оны хувьсгалаас хойш 1990-ээд оныг хүртэл үндсэндээ хаалттай байв. Хожим Д.Цэрэнсодном, Л.Хүрэлбаатар зэрэг эрдэмтэд дорвитой бүтээл туурвиж, судалгааны салхийг хагалсан билээ. Энэ талаар үл өгүүлэн харин “Саран хөхөөн намтар”, “Нарангэрэл дагины тууж”, “Гэсэр”, “Бурханы арван хоёр зохионгуй”-н зарим баримтад тулгуурлан реалист бус аргын эртний улбаа мөрийг өчүүхэн тодруулбал: Ногоон дарь эх 99 жил бясалгал диян хийсний хойно бурханаас үрийн хутаг гуйж шидэт үрлийн үрээр үр олж Оюу нэрт хүүгээ төрүүлнэ. Гэтэл гурав хоногийн дараа хүү нь ор сураггүй алга болсонд ихэд шаналан тэнгэр, асури, хүн, лус, там зэрэг бидний үл мэдэх орноор бядан хайж, зам мөрт тааралдсан зовж зүдэрсэн хамаг амьтанд өөрийн саамших сүүтээр “сүүн далай” үүсгэн буян нигүүсэл үзүүлж буй, “Гэсэрийн тууж”-д 500 жилийн өмнө Бурханы зарлигаар Хурмаст тэнгэр хөвүүнээ хүний ертөнцөд илгээх, тэр нь шид тарний хүчээр Амаржил хатны хэвлийгээр дамжих,

эхийн хэвлийд хүмүүс мэтгэлцэх хийгээд үдээс хойхно тэдгээр нь ээлж дараагаараа өөрийн нэр, зүс царай, үйлс, ирээдүйн тухай өгүүлэх, нэгдүгээр хүү Овоо Дүнжин гарво эхийн толгойн оройгоос гарч унаад эс баригдан зугатаж тэнгэр нар түүнийг авч одоход, хоёр дахь хүү эхийн баруун сугаар гарч эс гүйцэгдэхэд Лусын хаан авч явна. Гурав дахь хүүг гарахад эх хоёр сугаа хавчиж, толгойгоо дарж атал хүйснээс нь унаж дутаана. Түүнийг арван зүгийн дагинас авч одно. Дөтгөөр хүү Гэсэр Сэрво Дондүв эхийн “*ёстой мөрөөр төр*” гэснээр төрөхдөө “*баруун нүдээ хялайж, зүүн нүдээ харж, баруун гараа далайж, зүүн гараа атгаж, баруун хөлөө дээш өргөж, зүүн хөлөө жсийж, дөчин таван шүдээ зуусаар*” төрсөн / “Гэсэр” 22-р тал/ нь түүний цаашдын бүхий л хувилгаан шид /хувилах, мангас албиныг номхотгох, шулам, чөтгөрийг дарах, билгийн шидээр хүслээ биелүүлэх гм/ бүрдэж арван зүгийн хорын үндсийг таслаж буй нь яавч эгэл хүний ёс бус хүний романтик хүслэнгийн биелэл билээ. Иймэрхүү дүрслэлийн аргыг бид реализм гэхээсээ реалист бус романтик уран сэтгэмж гэх бодот байдалд нийцэх билээ.

“*Саран хөхөөн намтар*”-ын хан хөвүүн Номунбаясгалан, түүний найз түшмэлийн хүү хорон сэтгэлт Лагана нар аршаас нэгэн биеэс нөгөө биед хувиран орох эрдэм ухаан сурч хөхөө шувууны биед юүлэн муу нөхрийн балгаар зовлон эдэлсэн түүх “*Нарангэрэл дагины тууж*”-ийн хадам эхээ өөрийн гуяны махаар хооллож яваа үнэнч гэргий-дагины дүр зэрэг нь монголчууд уран сайхны янз бүрийн сэтгэлгээний баялаг туршлагатайг харуулна. Мөн үлгэр туулийн ерэн таван толгойт ендэр хар мангас, хорин таван толгойт хорголжин хар мангас, бүсгүй ба үнэг, чононд хувиран хүнтэй нөхцөгч шулам, ад тийрэн, там диваажингийн элдэв амьтсын давтагдашгүй дүр төрхийг бүтээсэн нь реалист бус сэтгэлгээ, дүрслэлийн болзолт аргын цогц системтэйг нотлох билээ.

Академич Д.Цэрэнсодном “*Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал*” /1977/-д монголын уран зохиолд буддын шашны нөлөө ХҮY зууны эхэн үеийн бүтээлүүд ч үзэгддэгийг дурьдаж, шашны зургаан зүйл амьтдын нэг бирдийн:

Айлан төдий хээлт

Уулан төдий тэргүүт

Асар нарийн хоолойт

Алхан ядах хөлтөн

хэмээсэн дүрслэл нь хүмүүн заяат амьтан буян эс хийж, нүгэл их үйлдвээс энэ мэт бирд болж зовно гэх агуулгыг энэ дэлхий дээр үл таарах нэгэн онцгой гаж дүрд шингээсэн нь монголчууд зөвхөн бодтойгоор дүрсэлдэг арга барилтай гэж үзэх нь үндэсгүйн нотолгоо мөн. “*Алтан хааны шүлэглэсэн намтар*” /1607-1610/ зохиолд “*маанийн зургаан үсгийн утга, тус чанар*” /Д.Ц.1997.230/-ыг Алтанхаан:

Эрхин ом үсэг тэнгэр нарын омогт төрөх үхэхээс тонилгож

Эрхт ма үсэг Асар нарын байлдан тэмцэлдэхээс тонилгож

Эл ни үсэг хүнийг дөрвөн зовлонгоос тонилгож

Жавхлант над үсэг адгуусны хэлгий мунхаг зовлонгоос тонилгож

Жич мэ үсэг бирдийн өлсөхүй, ундаасахуй зовлонгоос тонилгож

Жаргалан хун үсэг тамын хүйтэн халуун зовлонгоос тонилгох

утга шидтэйг тайлбарласан нь эл зургаан үсэг нь зургаан зүйл хамаг амьтны аймгийн сайн, муу явахын үүдэл шалтгааны бэлгэдэл болох нь чухамдаа сүмбэр уулнаа орших /оройд нь Тэнгэр нар, түүний дор Асури, дараа нь хүмүүн дөтгөөр дор адуусан, түүний дор бирд, адаг тамын орон/ зургаан зүйл амьтны орон байрлалын тухай шашны

бэлгэдэлтэй холбогддог. Энэ мэт уран сайхны реалист бус сэтгэлгээ, арга барилтай шууд хамаатай олон баримтыг “Чойжид дагины тууж”, “Маани хөгжсөөх шүлэг”, “Там, бирдийн магтаал”, “Молон тойны судар,” “Бодичарияаватарагийн тайлбар” зэргээс реалист бус дүрслэл, уран сэтгэмжийн болзолт хэв шинжийг олж үзэж болох юм.

Бөө мөргөлийн уран зохиолыг монголын эртний уран зохиолын ай савд хамруулан үзэх, эсвэл бэлгэдэл зүй, угсаатны аман зохиолын хүрээнд авч үзсэн хоёр зүйл баримтлал байдаг. Тухайлбал, Ц.Дамдинсүрэн “Монголын уран зохиолын тойм” I боть /1957/ номдоо “Монгол бөө мөргөл бол аман ба бичгийн хоёр төрлийн зохиолтой юм” /32/ гээд сан /Хийморь, Атаа тэнгэр, Цагаан өвгөний сан гм/, тахилга /галын, уул усны тахилга/, өчиг /Үрс гаргах өчиг/, дуудлага /Сүнсний дуудлага/, судар /Долоон өвгөний судар/ зэрэг төрөл хэлбэрийг дурдан бөө мөргөлийн бичгийн зохиол гээд аман зохиол нь бөөгийн дуудлага, зүхэл тамлага гэж үзжээ. Монгол бөө мөргөлийн уран зохиол, зан үйл, аман хэлбэрийг профессор академич Б.Ринчен, С.Дулам, Г.Гантогтох, доктор О.Пүрэв, Д.Банзаров зэрэг эрдэмтэд судалсан байна. Харин зан үйл, дуудлага, тамлага, онгод, онго шүтээн, шүлэглэлийн ур чадвар, агуулга, мөн чанарыг судлан сурвалжлах ажилд голлон анхаарч, бөөгийн бичгийн уран зохиол, аман уран бүтээлийн арга, найруулгын асуудлыг бага судалжээ.

Бөөгийн бичгийн ба аман уран бүтээлийн гол агуулга голчлон ертөнцийн хамаг бүхэн эзэн савдаг, онгодтой гэх үзэл бөгөөд тэдгээр эздийг мөргөж бишрэх, тахиж тайх зан үйлтэй нийлэг учраас юмс үзэгдлийг тусгахад бодот дүрслэл бус, харин оюун санааны хийсвэр дүрслэл, дүр давамгайлдаг аж. Ялангуяа тэнгэр, газар, уул усны эздийг угийн шид, онгодын хүчээр урин дуудаж, тахил ёслол үйлдэн, гуйх зүйлээ хүсээд өөр өөрийнх нь нутаг оронд буцааж буй өгүүлэмжээрээ шашны уран зохиолын адил цөм болзолт /орон биегүй/ ертөнцтэй харьцах харьцаа дүрслэлд давамгайлдаг. Шүтэж, урин дуудаж буй зүйлс нь ерэн есөн тэнгэр буюу тустай сайн тавин таван /барууны/, хор бачтай дөчин дөрвөн /зүүний/ тэнгэр нар нь тус тусын оногдсон үүрэгтэй “мэргээжлийн” тэнгэр, онгодууд байдаг тухай судлаачид тооцолж гаргасан зүйл /О.Пүрэв/ ч бий. Бөө мөргөл нь монголчуудын язгуурын шүтлэг /шашны/ бөгөөд бөө нар ч онгод шидийг олсон онцгой хүмүүс юм. Бидний үл мэдэх хоёр ертөнц /тэнгэр, лус, савдаг-бөө/ ийм холбоон дээр үүсдэг энэ уран зохиолын зүйлс нь мөн дан ганц реалист сэтгэлэг, аргад суурилдаг гэж үзэх нь учир дутагдалтай.

Манай уран зохиол судлаачид судалгааг цуваа цагийн үүднээс уламжлал шинэчлэл, хөгжлийнх нь хүрээнд авч үзэхээсээ илүү хэсэгчлэн цойлдох, нэгэн үеийг тасархайд авч үзэх, хэсэгчлэх, загварчлалд хэт автсанаас тодорхой үеүдийг нэг нь сөргөлдүүлэх, нөгөө нь үгүйсгэх, бусад нь илүүд үзэх хэтэрхийлэлд ямагт баригдсаар ирсэн билээ. Ялангуяа өдгөө хүртэл бичгийн уран зохиолтойгоо зэрэгцэн өөрийн жам зүйгээр хөгжсөөр буй амьд аман зохиол бүхий ард түмний уран зохиолыг судлахдаа тасархайд авч үзэх нь туйлын учир дутагдалтай. Уран зохиолын үечлэлийг олон эрдэмтэд хийсэн ч эдүгээ хүртэл нэгдмэл санал, тогтсон үечлэл гарсангүй. Уран зохиолыг үечлэн судлах нь судалгааг ямагт хязгаарлагдмал, тасалдалтай болгодгийг анхаарах шаардлага бий болжээ.

Эцэст тэмдэглэхэд шинжлэх ухааны нийтлэг нэр томъёо болсон романтизм, сентиментализм, реализм, абстракционизм, формализм, схематизм... зэрэг олон арга, найруулга монгол уран зохиолд олон зууны тэртээгээс хөгжиж боловсорсоор 1921 оны

ардын хувьсгалтай золгож, шинэ үеийн уран зохиолын эхний 20-30-аад жилд түүний уламжлал хүчтэй хэвээрээ байсан ажээ.

Социалист реализмын арга, онол 1940-өөд оноос өөрийн хэв шинжээ олох гэж эрэлхийлэх явцдаа хэлбэрдэх, хийсвэрлэх, загварчлах, бүдүүвчлэх, утга далдлах, зөгнөн мөрөөдөх гуниг гутралын гэх мэт нэр томъёогоор орлуулагдан цаг ямагт “нүд үзүүрлэгдэж” ирсэн уран бүтээлийн элдэв арга маягууд өөр өөрийн замаар удаан боловч хөгжсөөр 1990-ээд оны эхэнтэй золгосноор түүхэн уламжлал нь хараахан тасарчихаагүй үлдсэн гэж болно. Тэр суурь дээр нэн шинэ уран зохиолын өнөөгийн реалист бус чиг хандлага залган гарч ирсэн билээ.

НОМ ЗҮЙ

1. Билигсайхан Ч. (1988) *Монголын утга зохиол дахь сэргэн мандлын үеийг тодруулах асуудалд*. // "Цог" № 4 Улаанбаатар.,
2. Билигсайхан Ч. (1995) *Монголын уран зохиол дахь соён гэгээрүүлэх чиглэл, шүүмжлэлт реализмын асуудалд, Монголын уран зохиол судлалын унших бичиг*. Улаанбаатар.,
3. Белинский В.Г. (1956) *А.С. Пушкины зохиолууд. II өгүүлэл*. Москва.,
4. Буяннэмэх.С *Утга зохиолын үүд. УННС., /машиндмал эх/*
5. Галбаатар Д. (1994) *Монгол дууль*. Улаанбаатар.,
6. Галбаатар Д. (1999) *Монголын уран зохиолын аргын судалгаа УННС*. Улаанбаатар.
7. Бодоо Д. *Уянгат шүлэглэл. УННС Гар бичмэлийн фонд.*,
8. Жамсранжав Г. (1969) *Анхны алхам*. Улаанбаатар.,
9. Жамсранжав Г. (1975) *Уран сайхны ертөнцөд хийсэн сурвалжлага*, Улаанбаатар.,
10. Ёндон Д. (1970) "Үг" хэмээх зохиолын тухай. // *Монголын судлал. 13-р боть. ШУА*. Улаанбаатар.,
11. Кара Д. (1972) *Книги монгольских кочевников*. Москва.,
12. Конрад.Н.И. (1966, 1972) *Запад и Восток*. Науки. Москва.,
13. *Литературные связи Монголии*. (1981) Наука. Москва.,
14. Мөнх Ц. (1967) *Ардын яруу найргийн тухай тэмдэглэл*. Улаанбаатар.
15. *Монголын уран зохиолын түүх*. (1984) Хөх хот.,
16. *Монголын утга зохиол судлалын унших бичиг*. (1984) Улаанбаатар.,
17. *Нэгэн давхар асар*. (1957), Хөх хот.,
18. Heissig W. (1972) *Geschichte der mongolischen leteratur Band Weisbadeh.*,
19. Хийсвэр сэтгэлгээний урлаг. Соёл урлаг сонин УБ., 1996
20. Хорлоо П. (1975) *Монголын уран зохиолын уламжлал шинжлэл, ардын аман зохиол ба утга зохиол*. Улаанбаатар.,
21. *Хөөрөлдөөн*. (1997) Улаанбаатар.
22. Цэрэнсодном Д. (1987) *Монголын уран зохиол /XIII-XX зууны эхэн/* Улаанбаатар.,
23. Цэрэнсодном Д. (1987) *Монголын уран зохиол /XIII-XX зууны эхэн/* Улаанбаатар.,
24. Цагаан Д. (1968) *Д.Равжаа" Монголын уран зохиолын тойм. III боть*. Улаанбаатар.,
25. Цагаан Д. (1962) *Ориил "Ноён хутагт Д.Равжаа". Зохиолын эмхтгэл*. Улаанбаатар.,
26. Ринчен Б. (1948) *Из нашего культурного наследия*. Улаанбаатар.,
27. Сакулин П.Н (1929) *Русская литература. Социолого-синтетический обзорлитературных стилей. 4.2*. Москва.,
28. Энгельс.Ф (1955) *Диалектика природы*. Москва.,

SUMMARY

In this article, the author aimed to define the stages of Renaissance and peculiarities of Enlightenment age of Mongolian literature. Mongolian social status of that period, development attitude, new phenomena in literature, progress in genres and the authors' works and their results and significances have been studied. These have been proved by the written literary facts stemming from the 17th to the 20th century.